



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/218

Номгон


Аймгийн Онцгой комиссын Тандалт
судалгаа, ажиглалт, хяналтын шуурхай
бүлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.6, 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай” 02, “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/216 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 30 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд батлагдсан тохиолдлуудын хавьтлуудыг шуурхай тогтоох, тандалт судалгааны ажлыг хариуцсан аймгийн Онцгой комиссын Тандалт судалгаа, ажиглалт, хяналтын шуурхай бүлгийг томилсугай.

2.Аймгийн Онцгой комиссын Тандалт судалгаа, ажиглалт, хяналтын шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
26-ны өдрийн 218 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ТАНДАЛТ СУДАЛГАА, АЖИГЛАЛТ, ХЯНАЛТЫН
ШУУРХАЙ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай бүлгийн
дарга
Гишүүд

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн
Онцгой байдлын газрын дарга

Тагнуулын хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Шуурхай штабын дарга

Улсын бүртгэлийн хэлтэс

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар

_____оОо_____